



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН
ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ САЙД

Сүхбаатарын талбай 1, Чингэлтэй дүүрэг,

Улаанбаатар хот, 15160

Утас: 33 07 81, Факс: (976-11) 33 07 80,

Цахим шуудан: info@mddc.gov.mn


Цахим хуудас: www.mddc.gov.mn

додг. 11.04. № 01/1951
танай _____-ны № _____-т

Тайлан хүргүүлэх тухай

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 34 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам” болон холбогдох бусад хууль, тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрх зүйн актыг тус тус үндэслэн Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чиглэлээр зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг үүгээр хүргүүлж байна.

Хавсралт хуудастай.



Н.УЧРАЛ

0996091

Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын
2022 оны 11 дүгээр сарын 04-ны өдрийн
01/1931 дугаар албан бичгийн 1 дүгээр хавсралт

ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЛБАРЫН ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

2022 оны 10 дугаар сарын 28

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний гол зорилго нь харилцаа холбооны салбарт тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхлэх Зөвшөөрлийн тухай хуулийн холбогдох зохицуулалттай нийцүүлэн бэлэн байдлыг хангасан эсэхийг тодруулахад оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 34 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам” болон холбогдох бусад хууль, тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрх зүйн актыг тус тус үндэслэн Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чиглэлээр зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж гүйцэтгэв.

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон Харилцаа холбооны зохицуулах хорооноос олгох нийт 7 төрлийн тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаанд дээрх журмын дагуу **үр дүн, нотлох баримтад** тулгуурлав.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

➤ **Тоон гарын үсгийн гэрчилгээ олгох зөвшөөрлийн үйл ажиллагааны талаар:**

Цахим гарын үсгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт заасны дагуу “Интерактив” ХХК болон “Секьюрити солюшн, сервис консалтинг” ХХК нарын түншлэл-“Монпасс са” ХХК, “Нью компас” ХХК, “Ви эс эм” ХХК болон “Мөнхийн үсэг” ХХК нарын түншлэл-VSM ХХК, “Тридум э-секьюрити” ХХК, “Ай си ти групп” ХХК нар тоон гарын үсгийн гэрчилгээ олгох үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг эзэмшдэг. Мөн Улсын бүртгэлийн ерөнхий газар нь тусгай зөвшөөрөлгүйгээр иргэний цахим үнэмлэхэд тоон гарын үсэг олгохоор хуульд заасан байдаг.

Дээрх гэрчилгээжүүлэх байгууллагууд 2022 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар нийт 94,412 тоон гарын үсэг олгосон. Харин Улсын бүртгэлийн

ерөнхий газар дангаараа 265,318 иргэний цахим үнэмлэхэд тоон гарын үсэг олгосон байна.

Тоон гарын үсгийн тусгай зөвшөөрлийг Мэдээллийн технологи, шуудан харилцаа холбооны газрын даргын 2015 оны 72 дугаар тушаалаар батлагдсан “Тоон гарын үсгийн гэрчилгээ олгох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийг сонгон шалгаруулах журам”-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу тусгай зөвшөөрөл хүсэгч компанийг үнэлж, олгодог бөгөөд 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр мөрдөгдөж эхлэх Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэн ажиллахад аливаа хүндрэл бэрхшээл үүсэхээргүй байна.

➤ Харилцаа холбооны зохицуулах хорооноос олгогддог тусгай зөвшөөрлүүдийн талаар:

2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар зөвшөөрөл авахаар Харилцаа холбооны зохицуулах хороонд нийт 309 хүсэлт ирүүлснээс 158 хүсэлтийг шийдвэрлэж шинээр тусгай зөвшөөрөл олгосон байна.

Тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой үйл ажиллагаанд хяналт хийхэд дараах зөрчил дутагдал илэрсэн. Үүнд:

1. Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журамд заасан бүрдүүлэх баримт дутуу байхад тусгай зөвшөөрөл олгож байна. Тухайлбал бүрдүүлбэр материалд зөвшөөрөл хүсэгчийн санхүүгийн тайлан байхгүй, инженер техникийн ажилтны мэргэжлийн дипломын хуулбар гаргацгүй, ажлын туршлагын талаарх мэдээллүүд дутуу, бүрдүүлбэр материалын хуудас дугаарлалтгүй, шаардлага хангаагүй баримт хавсаргасан, хүсэлт гаргаснаас өөр зөвшөөрөл олгосон байна;

2. Санхүүгийн тайлангаар өр төлбөртэй эсэхийг нь болон төлбөрийн чадвартай эсэхийг нь тодорхойлохгүйгээр тусгай зөвшөөрөл олгосон;

3. Аж ахуйн нэгж байгууллагад олгох хүсэлтийг шийдвэрлэхдээ байгууллагын гүйцэтгэх захирал /хувь хүний/-ын дансны хуулгыг үндэслэж зөвшөөрөл олгосон;

4. Материалын бүрдэл хангуулахаар мэдэгдэл, зааварчилгаа өгөхдөө тэмдэглэл үйлдэж баримтжуулаагүй, нэмж ирүүлсэн материалыг бүртгэж хэвшээгүй;

5. Байгууллагын цахим хуудаст Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль болон Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 34 дүгээр тогтоолоор баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-д заасан зөвшөөрлийн нэршлээс өөрөөр байршуулсан;

6. Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан зарим гэрээний 2 дугаар хавсралтад 2 талаас хяналт тавьж ажиллах ажилтнуудын мэдээллийг тусгаагүй;

7. Сунгах хүсэлтэд тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас 60 хоногийн өмнө ирүүлсэн эсэхэд хяналт тавьдаггүй;

8. Хүсэлт хэлэлцэн шийдвэрлэсэн хорооны хуралдааны тэмдэглэлийг хэвлэмэл хуудаст буулгахдаа Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан Архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмыг мөрдөж ажиллаагүй байна. Тухайлбал 3 хуудас бүхий хорооны хуралдааны тэмдэглэлийг 3 ширхэг хэвлэмэл хуудаст гаргасан байна.

Дөрөв. Дүгнэлт

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журамд хамаарах 12 /арван хоёр/ шалгуур үзүүлэлтээр хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд ерөнхий

гүйцэтгэл 81,7%-тай үнэлэгдлээ. Шалгуур үзүүлэлт тус бүрээр гүйцэтгэлийг задлан үзүүлбэл:

- 30% -ын биелэлттэй 1 шалгуур үзүүлэлт
- 70% -ын биелэлттэй 5 шалгуур үзүүлэлт
- 100% -ын биелэлттэй 6 шалгуур үзүүлэлт байна.


Тав. Зөвлөмж

Харилцаа холбооны тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнд дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

1. Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг бүрэн цахимжуулах;
2. Байгууллагын албан ёсны цахим хуудаст тусгай зөвшөөрлийн нэр төрлийг хууль тогтоомжид заасан нэршлийн дагуу байршуулах, зөвшөөрөл хүсэгчдэд төөрөгдөл үүсгэхгүй байх;
3. Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаатай холбоотой хууль, тогтоомжийг мөрдөж ажиллах, дотоод хяналтыг сайжруулах;
4. Зөвшөөрөл хүсэгчээс ирүүлсэн материалын бүрдүүлбэрийг нягтлах, материалын хугацаа, агуулгыг сайтар хянах;
5. Зөвшөөрлийн тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж эхлэхээс өмнө олгосон хуульд зааснаас бусад зөвшөөрлийг цуцлах, мөн зөвшөөрөл олгох, цуцлахтай холбоотой харилцааг зохицуулж байгаа хэм хэмжээний актыг хүчингүй болсонд тооцож, Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлээс хасуулах арга хэмжээ авахаар ажлын хэсэг байгуулан ажиллах;
6. Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас өгсөн зөвлөмжийг мөрдлөг болгон тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд ахиц гаргахад шат дараалалтай арга хэмжээ авч ажиллах.

-----oOo-----

Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын
2022 оны 11 дүгээр сарын 04-ны өдрийн
01/1931 дугаар албан бичгийн 2 дугаар хавсралт



Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чиглэлээр тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд
хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан

2022 оны 10 дугаар сарын 28

Улаанбаатар хот

Д/д	Шалгуур үзүүлэлт	Тайлбар	Үнэлгээ
1	Шинээр тусгай зөвшөөрөл авах хүсэлтийн мэдээлэл	Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэхээр хуулийн этгээд хүсэлт гаргасан тохиолдолд тус хорооны ажлын алба иж бүрдлийг шалган хүлээн авдаг. Ирүүлсэн хүсэлтийн материал нь хууль, журам холбогдох бусад нөхцөл, шаардлагад нийцэж буй эсэхэд ажлын албадаар үнэлгээ дүгнэлт хийлгэж холбогдох ажлын албаны үнэлгээ хангалттай гэж үнэлсэн тохиолдолд тусгай зөвшөөрлийн мэргэжилтэн нэгтгэж, Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдаанд танилцуулан шийдвэрлэдэг. Хэрэв ирүүлсэн материал нь шаардлага хангахгүй, нэмэлт тодруулга мэдээлэл шаардлагатай тохиолдолд энэ талаар хүсэлт гаргагчид утсаар болон цахим хаягаар мэдэгдэж, ажлын 5 хоногийн хугацааг олгодог. Заасан хугацаанд материал ирүүлээгүй тохиолдолд шаардлага хангаагүй хэмээн үзэж тусгай зөвшөөрөл олгох боломжгүй тухай хариу хүргүүлдэг. Тус хороо нь хүсэлт гаргаж буй иргэн, хуулийн этгээдэд хүнд суртал үүсгэхгүй байх, авлига ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх зорилгоор тусгай зөвшөөрлийн асуудлыг аль болох хүнээс үл хамаарсан байдлаар шийдвэрлэхээр ажиллаж байна. Ингэхдээ тусгай зөвшөөрлийн асуудлыг ажлын алба тус бүр дээр хариуцаж байсныг тус хорооны захиргааны нэгж өөр дээрээ нэгтгэж, тусгай зөвшөөрлийн мэргэжилтэнд бүрэн хариуцуулж өгсөн бөгөөд хүсэлт гаргасан иргэн хуулийн этгээд нэг цонхоор, олон шат дамжлага багатайгаар хүсэлтээ шийдвэрлүүлэх боломжтой болсон. Мөн тусгай зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн санг цахимжуулж, тусгай зөвшөөрөл, бүртгэлийн гэрчилгээ, эрхийн бичиг зэргийг цахимаар авах программ хангамжийг бүрдүүлээд байна. Цаашид энэхүү цахимжуулалтын программ хангамжийг илүү боловсронгуй болгон хөгжүүлэлт хийхээр төлөвлөн ажиллаж байна. Тус хороонд 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар нийтдээ 186 шинээр тусгай зөвшөөрөл авах хүсэлт бүртгэгдсэн.	70

2	Хугацаа сунгуулахаар хандсан хүсэлтийн мэдээлэл	Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулахаар хүсэлт гаргасан тохиолдолд холбогдох материалыг хүлээн авч, холбогдох ажлын алба үнэлгээ дүгнэлт гарган шийдвэрлэдэг. Ингэхдээ хууль, журамд заасан хугацаанд багтааж, хүсэлтийг түргэн шуурхай шийдвэрлэхийн тулд Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 34 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам"-ын 4.4-т заасны дагуу тус хорооны дарга шийдвэрлэдэг. Харилцаа холбооны зохицуулах хороо нь орон тооны бус гишүүдээс бүрддэг бөгөөд хорооны дүрэмд заагдсаны дагуу сард 1-ээс доошгүй удаа хуралдаж, холбогдох асуудлыг шийдвэрлэдэг. Тусгай зөвшөөрлийн сунгалтын асуудлыг хорооны дарга шийдвэрлэснээрээ хүсэлт гаргасан хуулийн этгээдийн хүсэлт шуурхай шийдвэрлэгдэх боломжтой болсон. Энэ тохиолдолд үнэлгээ дүгнэлт нь шаардлага хангасан тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах хүсэлтийг 7 хоног бүр тушаал гарган шийдвэрлэж байна. Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулах процессыг илүү тодорхой, түргэн шуурхай, хүнд сурталгүй болгох зорилгоор тусгай зөвшөөрлийн сан бүрдүүлэх, баяжуулах ажлыг шат дараатайгаар хэрэгжүүлж байна. Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулах хүсэлт гаргасан этгээдийн талаарх бүх төрлийн мэдээллийг төвлөрүүлж баяжуулснаар тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулах хүсэлтийг хуульд заасан богино хугацаанд шийдвэрлэх нөхцөл боломж бүрдэх юм. 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар хугацаа сунгуулахаар хандсан 109 хүсэлт бүртгэгдсэн.	30
3	Зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийг шилжүүлэхээр хандсан мэдээлэл	Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн эзэмшиж буй тусгай зөвшөөрлийн хамрах хүрээ, эрхлэх үйлчилгээний төрөл, ашиглаж буй радио давтамжийн зурвас, эзэмшигчийн нэр зэрэг холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд "Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам"-ын 5 дугаар зүйлд заасны дагуу хүсэлтээ гарган шийдвэрлүүлдэг. 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийг шилжүүлэхээр хандсан 14 хүсэлт бүртгэгдсэн.	100
4	Буцаасан хүсэлтийн мэдээлэл	Тусгай зөвшөөрөл шинээр авах, хугацаа сунгуулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, шилжүүлэхээр ирүүлсэн хүсэлтийн материал нь холбогдох хууль журамд заасан шаардлагыг хангаагүй, иж бүрдэл дутуу тохиолдолд хүсэлтийг шийдвэрлэхээс татгалзаж, албан бичиг хүргүүлдэг. Албан бичиг ямар шалтгааны улмаас буцааж байгаа тухайгаа дэлгэрэнгүй дурдаж, холбогдох шаардлагыг хангуулах дахин хүсэлтээ гаргах боломжтой тухай дурддаг. 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар 22 хүсэлт буцаасан.	70

5	Тусгай зөвшөөрөл олгосон мэдээлэл	Харилцаа холбооны зохицуулах хороо нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.16-д заасан тусгай зөвшөөрлүүдийг олгож, гэрээ байгуулж, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. Шинэчлэн батлагдсан Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу тус хороо нь 14 төрлийн тусгай зөвшөөрөл, 1 төрлийн энгийн зөвшөөрөл олгох бөгөөд тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан асуудлаа салбарын хууль тогтоомж болох Харилцаа холбооны тухай, Радио долгионы тухай, Шуудангийн тухай, Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд тусган зохицуулахаар саналаа бэлтгэн ажиллаж байна. Энэ тохиолдолд харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх иргэн, хуулийн этгээдэд хууль эрх зүйн орчин илүү тодорхой, ойлгомжтой болох нөхцөл бүрдэнэ. Мөн Зөвшөөрлийн тухай хууль батлагдсантай холбоотойгоор тус хорооны даргын тушаалаар өргөн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдаж хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актууд, дотоод баримт бичгүүдэд үзлэг хийж, нэмэлт өөрчлөлт оруулахаар ажиллаж байна. 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар нийт 159 тусгай зөвшөөрөл олгосон.	70
6	Түдгэлзүүлсэн тусгай зөвшөөрлийн мэдээлэл	Тусгай зөвшөөрлийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13 дугаар зүйл, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 14 дүгээр зүйл, Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журмын 6 дугаар зүйлд заасан үндэслэлээр 3 хүртэл сарын хугацаагаар түдгэлзүүлдэг. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа явуулж, эрх ашиг нь хөндөгдөх талаас холбогдох тайлбар, мэдээллийг авдаг. Түдгэлзүүлсэн шийдвэр гарсан тохиолдолд энэхүү шийдвэрийг тусгай зөвшөөрөл эзэмшигч болон татварын албанд албан бичгээр мэдэгддэг. Түдгэлзүүлсэн хугацаанд тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрэглэгч бүртгэхгүй, үйл ажиллагаагаа өргөтгөх боломжгүй байдаг. 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар нийт 22 тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн.	70
7	Сэргээсэн тусгай мэдээлэл	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3, Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журмын 6 дугаар зүйлийн 6.6-д заасны дагуу тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн шалтгаан нөхцөл арилсан тохиолдолд тусгай зөвшөөрлийг сэргээх арга хэмжээ авч хэрэгжүүлдэг. 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар нийт 18 тусгай зөвшөөрлийг сэргээсэн.	100

8	Хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн мэдээлэл	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, Харилцаа холбооны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, Радио долгионы тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 16 дугаар зүйл болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан нөхцөл үүссэн тохиолдолд ХХЗХ-ны шийдвэрээр тусгай зөвшөөрлийг хүчингүй болгодог. Хүчингүй болгох нөхцөл үүссэн тохиолдолд энэ талаар эрх ашиг нь хөндөгдөх талуудад Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа явуулж, холбогдох тайлбар мэдээлэл гаргаж өгөх бололцоог олгодог. 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар нийт 26 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож шийдвэрлэсэн.	100
9	Дуусгавар болгосон тусгай зөвшөөрлийн мэдээлэл	Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулах хүсэлтээ хууль журамд заасан хугацаанд ирүүлж, шийдвэрлүүлээгүй, тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр хугацаа дууссан тохиолдолд энэ талаар тусгай зөвшөөрөл эзэмшигчид мэдэгдэж, тусгай зөвшөөрөл дуусгавар болдог. Тусгай зөвшөөрлийн хугацаа дуусгавар болсон тохиолдолд тус хорооны тусгай зөвшөөрлийн бүртгэл мэдээллийн санд өөрчлөлт оруулдаг. 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар нийт 87 тусгай зөвшөөрлийг дуусгавар болгосон.	100
10	Байгуулсан гэрээний мэдээлэл	Тусгай зөвшөөрөл олгосон, нэмэлт, өөрчлөлт оруулсан, хугацаа сунгасан тухай шийдвэр гарсан тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй тусгай зөвшөөрлийн гэрээ байгуулах ажлыг эхлүүлдэг. Тусгай зөвшөөрлийн тухай шийдвэр гарсны дараа тусгай зөвшөөрлийн гэрээний төслийг холбогдох талд тусгай зөвшөөрлийн программаар дамжуулан илгээдэг. Гэрээний төслийг баталгаажуулан ирүүлсэн, төлбөр тооцооны үлдэгдэлгүй тохиолдолд тусгай зөвшөөрлийн гэрээг баталгаажуулан, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хамт олгодог.	70
11	Нөхөж олгосон тусгай зөвшөөрлийн гэрчилгээний мэдээлэл	Тусгай зөвшөөрлийн гэрээ, гэрчилгээний эх хувийг үрэгдүүлсэн, гэмтээсэн тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигч гэрээ, гэрчилгээг нөхөж олгох хүсэлтийг зарлуулсан тухай холбогдох баримтын хамт Зохицуулах хороонд ирүүлэх ба Зохицуулах хороо нь “Нөхөж олгов” тэмдэглэл хийж олгох асуудлыг шийдвэрлэдэг. 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар тусгай зөвшөөрлийн гэрчилгээгээ нөхөж олгуулахаар хандсан хүсэлт байхгүй.	100
12	Тоон гарын үсгийн тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны талаар	Тусгай зөвшөөрлийг Мэдээллийн технологи, шуудан харилцаа холбооны газрын даргын 2015 оны 72 дугаар тушаалаар батлагдсан “Тоон гарын үсгийн гэрчилгээ олгох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийг сонгон шалгаруулах журам”-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу тусгай зөвшөөрөл хүсэгч компанийг үнэлж, олгодог. Журамд заасны дагуу дараах шаардлагуудыг хангасан тохиолдолд тусгай зөвшөөрлийг олгодог. Үүнд: -Гэрчилгээжүүлэх байгууллага нь хөрөнгө оруулалт болон үйл ажиллагааг 500 сая ба түүнээс дээш төгрөгийн санхүүжилтээр эхлүүлэх чадвартай байх; -100 сая ба түүнээс дээш төгрөгийн хариуцлагын даатгалтай байх; -Мэдээллийн аюулгүй байдал хариуцсан, тухайн байгууллагад үндсэн ажилтнаар 18 сараас доошгүй хугацаанд ажилласан, 2-оос доошгүй тооны мэргэшсэн ажилтантай байх;	100

	<p>-Системийн удирдлагын асуудал хариуцсан тухайн байгууллагад үндсэн ажилтнаар 18 сараас доошгүй хугацаанд ажилласан, 2-оос доошгүй тооны мэргэшсэн ажилтантай байх;</p> <p>-Дотоод аудит хариуцсан ажилтантай байх;</p> <p>-Тоон гарын үсгийг гэрчилгээ нь Олон Улсын Цахилгаан Холбооны Байгууллагын ITU-T X.509 стандартын хувилбар 3-ыг хангах;</p> <p>-Гэрчилгээжүүлэх үйл ажиллагааны журам нь Интернэтийн инженерчлэлийн мэргэшсэн багийн IETF RFC 3647 стандартыг хангах;</p> <p>-Аюулгүй байдлыг хангах арга хэмжээ нь MNS/ISO17799:2007/, MNS/ISO 27001:2007/ стандартыг тус тус хангасан байх.</p>	
Нийт	<p>Дээрх тайлбар болон Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журмын дагуу тусгай зөвшөөрөл олголтын үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийсэн.</p>	81.7